



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 1/05

Рашаант сум

**Гол мөрний хадаагаар зорчихыг
хориглох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Авто тээврийн тухай хуулийн 7.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гол мөрний мөсөн бүрхүүл нимгэн байгаатай холбогдуулан иргэдийн аюулгүй байдлыг хангах, аливаа осол эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Сэлэнгэ мөрөн, Хануй голын хадаагаар зорчихыг хориглосугай.

2. Цаг хожих, зам товчлох зэргээр голын мөсөн дээгүүр тээврийн хэрэгсэлтэй зорчихгүй байх, голын мөсөн дээр хүүхдийг харгалзах хүнгүйгээр тоглуулахгүй байхыг нийт ард иргэд, тээврийн хэрэгслийн жолооч нарт анхааруулсугай.

3. Тээврийн хэрэгсэл бүхий албан газар, аж ахуйн нэгж, иргэдэд энэхүү захирамжийг сурталчлан, аливаа ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч (Н.Энхжил), цагдаа (Б.Наранбаатар), багийн Засаг дарга нарт даалгасугай.


Б.АЛТАНГЭРЭЛ